

Академич, профессор Ш. Нацагдорж таны 70 насны ирмүүн бүтээлч энэ ойг тохиолдуулан Дорнодахины судлалын хүрээлэнгийн хамт олон, тус сэтгүүлийн редакцийн зөвлөл чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж эрдэм судлалын нөр их үйлсэд чинь улам их амжилт хүсч байна.

ШУА-ИЙН СУРВАЛЖЛАГЧ ГИШҮҮН

Н. ИШЖАМЦЫН 60 НАС

1988 оны тавдугаар сарын 5-нд манай нэрт түүхч, ШУА-ийн сурвалжлагч гишүүн, түүхийн ухааны доктор Нямбуугийн Ишжамц 60 нас хүрлээ. Манай улсын шинжлэх ухааны хүрээлэн (тэр үеийн нэр)-гийн түүхийн тасаг 1953 онд нэгэн авьяаслаг залуу судлаачаар нэмэгдсэн нь тэр жил Москвагийн Улсын Их сургуулийн түүхийн ангийг төгсгөж ирсэн ирээдүйн эрдэмтэн Н. Ишжамц байлаа.

Тийнхүү Н. Ишжамц эрдэм судалгааны ажилд авьяас билгээ зориулж ШУА-д тасралтгүй ажилласан 35 дахь жил дээрээ 60 насныхаа ойтой золгож байна. Сурах, хөдөлмөрлөх хоёрыг байнга хослуулж ирсэн нь Н. Ишжамцын эрдмийн үйл ажиллагааны нэг онцлог юм. Тэрээр 1957-1960 онд Бээжингийн их сургуулийн аспирантурт суралцаж төгсөөд тус Академийн түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажилласан бол 1972 онд Москвад түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж ирээд тэр үед шинэ тулгар байгуулагдсан ШУА-ийн Ази, Африкийн хэлтсийн дарга, Дорнодахины судлалын хүрээлэнгийн орлогч захирал, захирлаар 1988 оны 9-р сар буюу 60 насныхаа өндөрлөгийг давтал хүчин зүтгэж одоо мөн хүрээлэндээ эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар ажиллаж байна.

1982 онд ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгогдсон д-р Н. Ишжамц 1960— 1970-аад онд судалгаа шинжилгээнийхээ ажлыг Монголын түүхийн харьцангуй бага судлагдаж, «цагаан толбо» болж байсан дундад зууны үеийн үндэсний эрх чөлөөний тэмцэл хөдөлгөөн, Монголын төрт ёсны үүсэл хөгжил, монголчуудын угсаа язгуур, үндэстэн бүрэлдсэн түүх, түүнчлэн Төв Азийн нүүдэлчдийн түүх соёл зэрэг сэдвүүдээр ажиллаж олон тооны бүтээл туурвиснаараа эх орны түүхийн шинжлэх ухаанд чамлашгүй хувь нэмэр оруулсан юм. Түүний бичсэн «Амарсанаа, Чингүнжав нарын бослого» (1962), «Монголын феодалын нэгдсэн төр байгуулагдсан нь» (1972) зэрэг эрдэм шинжилгээний арга зүйн өндөр түвшинд бичигдсэн нэгэн сэдэвт, даацтай бүтээлүүд нь Монголын түүхийн ном зүйн сан хөмрөгт зүй ёсоор хүндтэй байр эзэлдэг юм.

Сурвалжлагч гишүүн Н. Ишжамц 80-аад оны судалгаагаа хятад, дорнодахины судлалд голлон чиглүүлж монголын түүхийн зангилаа асуудлаар байнга ажиллахын зэрэгцээ Хятадын түүхийн нэн эртнээс эхлэн өнөө хүртэлх тоймыг харуулсан «Балар эртний хятадын түүхийн зарим асуудал», «Эзэн боолын нийгэмлэгт эртний хятад улс», «Феодалын хятад улс», «Хятадын хөрөнгөтөн-газрын эздийн Бүгд Найрамдах Улс»,

«Хувьсгалын дараахь БНХАУ-ын тойм (1949—1985) зэрэг цуврал өгүүллүүд нийтлүүлсэн юм.

Монголын ард түмний түүх бол Хятадын түүхийн нэг хэсэг биш, биеэ дааж тусгаар тогтносон улс түмний түүх, монголчуудын нүүдэл, иргэншил нь Монголын ард түмний өөрийн соёл бөгөөд Хятадаас гадна Түрэг, Иран, Төвд, Орос зэрэг ард түмний соёлтой нягт харилцаатай хөгжиж ирснийг нотлон дүгнэсэн нь Н. Ишжамцын бүтээлүүдийн гол шижим болно. Ялангуяа түүний оролцон бичсэн ерөнхий боловсролын дунд сургуулийн 9—10-р ангид үзэх «БНМАУ-ын түүх»-ийн сурах бичиг нь 1981, 1985 онд тус тус хэвлэгдэж өсвөр үеийг түүхээр хүмүүжүүлэх арвин үйлсэд дорвитой нэмэр хандив болсоор байна.

Сурвалжлагч гишүүн Н. Ишжамцын өргөн бөгөөд гүн мэдлэг, түүний цар хүрээ нь үргэлж үлгэр дууриалал болж байдаг юм. Тэрээр БНМАУ-ын түүхийн нэг болон гурван боть зохиолд зохиогч, редактороор оролцсоноос гадна, «XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн Монгол дахь үндэстний эрх чөлөөний хөдөлгөөн» (1975 он орос, англи хэл дээр), «БНМАУ-ын түүхийн зарим асуудал» (1984), 1988—1989 онд хэвлэгдэх «Төв Азийн иргэншлийн түүх» (6 боть олон улсын хамтын бүтээл) зэрэг 30 гаруй бүтээлд зохиогч, редактороор хамтран оролцож эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт зохиол, товхимол, өгүүлэл, шүүмж 80 гаруйг бичсэнээс гадна ЗСБНХУ, АНУ зэрэг гадаад оронд болон дотоодод болсон эрдэм шинжилгээний олон удаагийн их, бага хурлуудад илтгэл тавьж идэвхтэй оролцон эх орныхоо шинжлэх ухааныг нэр төртэй төлөөлж ирлээ.

Н. Ишжамц 1975 оноос Ази, Африкийн эв санааны нэгдлийн Монголын хорооны орлогч дарга, Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ахмад эрдэмтэн, чадварлаг зохион байгуулагч, тус сэтгүүлийн ууган редакторын нэг Н. Ишжамц Таны 60 насны ойд хүрээлэнгийн хамт олон болон «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлийн редакцийн зөвлөл чин сэтгэлийн баяр хүргэж, энх тунх явж эрдэм судлалын ажилдаа улам их амжилт гаргахыг хүсэн ерөөж байна.